



ХҮДЭР СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.07.30 № САА 2020/04-НА-16
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хүдэр сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хүдэр сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

.. 018020568

Дүгнэлт

Хүдэр сумын Монгол Ардын намын хорооны Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хүдэр сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...6... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Хүдэр сум
2020 он

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР



2020.06.22

БИДНИЙ УРИА: ХАМТЫН ХҮЧЭЭР СУМАА ХӨГЖҮҮЛЬЕ.
ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЕ.

Хүдэр нутгийнхаа зон олны итгэл, сонголтыг хүлээн ялалт байгуулахыг зорьж Монгол Ардын Нам ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтайгаа хамтран хичээл зүтгэлтэй ажиллаж ирсэн билээ.

Бид бүхэн орон нутгийнхаа иргэдийн ололт амжилт, хуримтлуулсан туршлага, нөөц боломжид тулгуурлан ирэх 4 жилд “Хамтын хүчээр сумаа хөгжүүлье, Хөгжлийн төлөө хүчээ нэгтгэе” уриатайгаар та бидний өмнө тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхээр энэхүү хөтөлбөрөө боловсруулж Хүдэр сумын нийт ард иргэд, Сонгогч танаа танилцуулж байна.

Нэг. Нийгмийн бодлого.

1.1. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн хувьд хүн амд ээлтэй, тэгш хүртээмжтэй, чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэнэ.

- 1.1.1 Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулах ажлыг жилд 2-оос доошгүй зохион байгуулж, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн үр дүн чанарыг сайжруулна.
- 1.1.2 Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэх арга хэмжээг улирал бүр зохион байгуулна.
- 1.1.3 Жил бүр ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2-оос доошгүй хамруулах арга хэмжээ авна.
- 1.1.4 Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан, улирал тутамд явуулын баг ажиллуулж малчин өрх бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- 1.1.5 “Соёлч-Өрх”, “Цэвэр-гудамж” уралдааныг жил бүр шалгаруулан туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.



1.1.6 Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтныг орон тоогоор нь бүрэн ажиллуулж, лабораторийн үйл ажиллагааг тогтмолжуулан багаж, тоног төхөөрөмжөөр хангана.



1.2. Боловсрол, соёл, спорт

Эрдэм боловсролтой, түүх ёс заншил, уламжлалт соёлоо дээдэлсэн “Зөв монгол хүүхэд”-ийг төлөвшүүлнэ.

1.2.1 ЕБС-ийн барилгад их засвар оруулах, материаллаг баазаар хангах талаар анхаарч ажиллана.

1.2.2 ЕБС-ийн байгалийн ухааны лабораторийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмж хичээл, сургалт хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.3 Ахмадуудын /урлагийн их наадам/ ахмад тамирчдын спортын их наадмыг сумандаа зохион байгуулах талаар анхаарч ажиллана.

1.2.4 Төрийн өмчийн болон хувийн аттестатчилагдсан магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, шаталсан сургалттай коллежид амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг “Үндэсний тэтгэлэг” хөтөлбөрт хамруулах талаар холбогдох байгууллагад уламжилна.

1.2.5 Орон нутаг судлах танхимыг нутгийн онцлогт тохируулан түүх, соёл, өв уламжлалаа сэргээн дээдэлсэн “Соёлын өргөө” болгон шинэчлэн тохижуулна.

1.2.6 Сумын төвд хөл бөмбөг, гар бөмбөг, сагсан бөмбөг, гүйлтийн задгай талбай барьж байгуулах талаар холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

1.2.7 Сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагын дунд жил бүр урлаг, спортын наадам зохион байгуулна.

1.2.8 Соёлын төвийг мэргэжилтэй боловсон хүчин, материаллаг баазаар үе шаттай хангах, номын сангийн фондыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллана.

1.3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрлэл.


Нийгмийн халамжийн боломжит бүх үйлчилгээг шуурхай хүргэж, баялаг бүтээгчдийг дэмжиж өрх бүрийн орлогыг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулна.

1.3.1 ХЭДС-аар олгогдох зээлд өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, ажлын байрыг нэмэгдүүлсэн иргэн ААН-ийг хамруулах тал дээр анхаарч дэмжиж ажиллана.

1.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулж төсөл хөтөлбөрт хамруулна.

1.3.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ТББ-уудтай идэвхтэй хамтран ажиллана.



- 
- 1.3.4 Уул уурхайн үйлдвэрт тогтвортой ажлын байр хадгалах зорилгоор Хүдэр сумын иргэдийг ажлын байранд авч, уул уурхайн нарийн мэргэжлийн курст суралцуулж, мэргэжил эзэмшүүлнэ.
- 1.3.5 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажлын байрны 45 хүртэлх хувьд орон нутгийн иргэдийг ажиллуулна.
- 1.3.6 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зохих хөнгөлөлттэй амралт сувилалд амруулах ажлыг жил бүр зохион байгуулна.
- 1.3.7 Ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийг түлээ, түлшээр хангах талаар анхаарч ажиллана.
- 1.3.8 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж " Монгол гэрийн мод - гэр ахуйн модон эдлэл" үйлдвэрлэлийг үргэлжлүүлэн дэмжин сумын Брэнд бүтээгдэхүүнтэй болно.
- 1.3.9 Хус, нарсан ойн нөөцийг ашиглан хавтан, модон эдлэлийн үйлдвэрлэл явуулах иргэд, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 1.3.10 "Тэргүүний аж ахуйч өрх"-ийг жил бүр шалгаруулан туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Эдийн засгийн бодлого.

2.1. Хүнс хөдөө аж ахуй

Байгаль цаг уурын эрсдэл даах чадвар бүхий эрчимжсэн мал аж ахуй газар тариалангийн салбарыг хөгжүүлнэ.

- 2.1.1 Хагас эрчимжүүлсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжин үйлдвэр угсааг сайжруулж сүү мах, ноос ноолуур таваарлаг чанарыг нэмэгдүүлэн сайн үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгчээр дэс дараатай хангана.
- 2.1.2 Сум орон нутагт сүү хөргөх төхөөрөмж бүхий хөргүүрийг шинээр суурилуулна.
- 2.1.3 Мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж явуулын үзлэг, оношилгоо эмийн үйлчилгээг тогтмолжуулна.
- 2.1.4 Малчдын нөхөрлөл, бүлэг хоршоо, сум орон нутагтаа 20-оос доошгүй жил амьдарч байгаа тэтгэврийн насны иргэдийг малжуулах төсөл хөтөлбөрт хамруулна.
- 2.1.5 Хүн, мал амьтны усан хангамжийг сайжруулж, бэлчээрт худаг уст цэгийн тоог нэмэгдүүлж зүй зохистойгоор бэлчээрийн даацыг ашиглах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.6 Өрхийн үйлдвэрлэгч, хоршоо, бүлгийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж төмс, хүнсний ногоо, зoorь, хүлэмж, зөгийн аж ахуйг нэмэгдүүлнэ.



- 2.1.7 Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, төмс, хүнсний ногоо тариалагч хоршоо, нөхөрлөлийн тариалсан төмс, хүнсний ногоог зах зээлд нийлүүлэх сүлжээ боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.8 Тариалангийн үйлдвэрлэлд таримлын зохистой сэлгээ мөрдөж, сэлгээнд ашигт таримал тариалсан, шинээр усалгаатай тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.9 Бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх зорилгоор алсын бэлчээрийг усжуулах, зам, давааг засан сайжруулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.

2.2. Байгаль орчин


Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж нөхөн сэргээх, усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулна.

- 2.2.1 Сумын байгаль орчны талаар баримтлах цогц бодлогыг шинэчлэн боловсруулж хууль тогтоомжийн дагуу мөрдүүлж ажиллана. /сумын ойн нөөцийг тогтоож, ойн менежментийн төлөвлөгөөг шинэчилж хийнэ /
- 2.2.2 Шинээр баригдах барилга байгууламжийн эргэн тойронд ногоон байгууламж байгуулах асуудлыг зохион байгуулж, орчны хог, хаягдлын сөрөг нөлөөллийг багасгана.
- 2.2.3 Сумын төвийн хогийн цэгийг хашаажуулж, харуул хамгаалалттай болгоно.
- 2.2.4 Бүх нийтээр мод тарих үндэсний хөтөлбөрийн дагуу айл өрх, албан байгууллага бүрд жимс жимсгэнийн болон гоёлын мод бут тарих, сургалтыг зохион байгуулж, гаргасан санал санаачилгыг дэмжин ажиллана.
- 2.2.5 Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг шат дараатай зохион байгуулна.
- 2.2.6 Булаг шандын эхийг хамгаалж хашаажуулна. /Жаргалант, Номтын рашаан, Баянцагааны булаг... /
- 2.2.7 Байгаль орчноо хамгаалж, ажилгүй иргэдээр ойн цэвэрлэгээ хийлгүүлж зэргэлдээх сумдын түлшний хэрэгцээг хангана.
- 2.2.8 Уул уурхайн олборлолт явагдаж орхигдсон газруудыг байгальд хоргүй аргаар дахин ашиглуулан нөхөн сэргээх бодлогыг бичил уурхай эрхлэгчид, нөхөрлөлүүдээр хийж гүйцэтгүүлнэ.
- 2.2.9 Гол усны урсац бүрдэх эх, ойн сан болон усны сан бүхий газарт ашигт малтмал эрж хайх, олборлохыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, уул уурхайн нөхөн сэргээлтийг хийлгэх ажлыг зөвшөөрөлтэй эрх бүхий аж ахуй нэгжүүдээр гүйцэтгүүлнэ.



2.3. Дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдаа үйлчилгээ

Орон нутгийн хөгжлийг эрчимжүүлж, иргэд оршин суугаа газартаа ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.



- 2.3.1 Спортын ордныг шинээр барих ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээг авна.
- 2.3.2 Цахилгаан эрчим хүч дамжуулах сумын төвийн хорооллын дундах О.4-кв-ын шугамыг засварлаж, эрчим хүчний доголдлыг арилгаж, хүчдэлийг тэнцвэржүүлэх ажлыг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 2.3.3 Сумын төвийн хайрган хучилттай замыг сайжруулан засварлах ажлыг жил бүр гүйцэтгэж найрамдал хорооллын дундах дутуу 1 км замыг шинээр хийж, Хөдөөд Буурал овоо, Шавартай хошууны замыг засварлана.
- 2.3.4 Сумын инженерийн шугам сүлжээ болох цэвэр бохир, халуун хүйтний шугам хоолойг шинэчлэн, засварлах ажлыг үе шаттай, ээлж дараалалтай хийж гүйцэтгэх талаар анхаарч ажиллана.
- 2.3.5 Нутгийн зам хөтөлбөрт Хүдэр самбараас сумын төв хүрэх 9,5 км замыг хамруулах тал дээр анхаарч, холбогдох байгууллагад уламжилна.
- 2.3.6 Хоггүй сум болох аяныг өрнүүлж, хог хаягдлыг дахин боловсруулах цехийг бий болгох, нийтийн эзэмшлийн гудамж талбайд хогийн савыг нэмэгдүүлж, хог хаягдлыг багасгах санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 2.3.7 Сумын төвийн айл өрхүүдийн дунд уст цэг, цахим худгийг барьж байгуулна.
- 2.3.8 Сумын төвд залуу гэр бүлийг орон сууцжуулах зорилгоор 20 айлын орон сууц барих, ипотекийн зээлд хамруулах талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 2.3.9 Иргэдийнхээ аятай тухтай амьдрах нөхцөлийг хангаж, худалдаа үйлчилгээний чанар стандартыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3.10 "Хүдэрт үйлдвэрлэв" хөдөлгөөн өрнүүлж, сумын брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангаж ажиллана.
- 2.3.11 Тарвагатай нэгдүгээр багийн Бугат, Согоот хороолол, Баянцагаан 2-р багийн Дэнж, Хайрхан, Бэлчир, Булаг хорооллуудад гудамжны гэрэлтүүлэг шинээр суурилуулна.
- 2.3.12 Баянцагаан гармын хоёр талд шинээр гүүр далан шинээр барьж байгуулна.
- 2.3.13 Сумын хэмжээнд Бэлчир Найрамдал хороололд хүүхдийн тоглоомын талбайг бий болгоно.



2.4. Төсөв санхүү

Төсвийн ил тод байдлыг иргэдэд нээлттэй болгож, шилэн дансны хяналтыг чанаржуулна.

- 2.4.1 Орон нутгийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, гүйцэтгэлийг иргэдэд ил тод мэдээлж ажиллана.
- 2.4.2 Төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалтын тендерийн сонгон шалгаруулалт болон гүйцэтгэлийг үе шаттай иргэдийн оролцоотойгоор хяналт тавьж, шударгаар дүгнэж иргэдэд тайлагнана.
- 2.4.3 Орон нутгийн төсөв болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг иргэдийн оролцоотой төлөвлөн тэдний амин чухал хэрэгцээг хангахад зориулан зарцуулан ажиллана.

Гурав. Нутгийн захиргаа хууль эрх зүйн бодлого

3.1. Төрийн захиргаа

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна.

- 3.1.1 Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, иргэдийн чирэгдэл, зардлыг багасгах зорилгоор төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.2 Багш, эмч, сувилагч, соёлын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, туршлага эзэмшүүлэх зорилгоор гадаад, дотоодод туршлага судлуулах, сургалтад хамруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2. Хууль хяналт

Иргэдийн аюулгүй байдлыг хангаж хууль ёсыг сахиулна.

- 3.2.1 Байгаль орчныг хамгаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд эрх зүйн боловсрол эзэмшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг иргэд албан байгууллагын дунд зохион байгуулна.
- 3.2.2 Эрэн хайх аврах салбарын үйл ажиллагааг дэмжин авто граж барьж байгуулна.
- 3.2.3 Малын хулгайтай тэмцэх зорилгоор малчдын зөвлөл байгуулахыг дэмжиж ажиллана.

ХҮДЭР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

